



ДУНДГОВЬ АЙМАГ  
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 03 өдөр

Дугаар 4/5

Аргатай


Г Морины уралдааныг зохион  
байгуулахыг хориглох тухай Г

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолын 57.1, Хүний эрхийн үндэсний комиссын 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 1/05 тоот зөвлөмж, аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/279 тоот албан бичгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан болон үсэргээ сунгаа зохион байгуулахыг хориглосугай.

2. Өвөл, хаврын байгаль цаг агаарын таагүй нөхцөлд морины уралдаан зохион байгуулахад үүсч болзошгүй сөрөг нөлөө, үр дагаварыг олон нийт ялангуяа уяачид, эцэг эхчүүдэд сурталчилан таниулахыг уяачдын холбооны тэргүүн (Б.Цогтгэрэл), Багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд онцгойлон хяналт тавьж ажиллахыг цагдаагийн мөрдөгч (С.Болдхэт), нийгмийн бодлогын мэргэжилтэн (Э.Долгорсүрэн), Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.



482301047

This PC/local disk(D)2023 он/ээз-н актууд/захирамж 2023